

ДИЗАЙН –ЗУРАГ ЗҮЙ



СЭДЭВ: ГРАФИК ДИЗАЙНЫ ЗОХИОМЖ БА ХЭЛБЭРИЙН ЭЛМЕНТУУД

Зорилго: Цэг ,шулуун
,хавтгайн зохиомжийн
зарчимаар чимэглэл зурах.

ЗОРИЛТ

- График дизайны зохиомжийн тухай.
- Хавтгайн зохиомжийн ба хэлбэрийн элементүүдийн ангилал.
- Зохиомжийн төвийн тухай ойлголт .
- Зохиомжийн хууль байгуулалтын арга элементүүд.

ГРАФИК ДИЗАЙНЫ ЗОХИОМЖИЙН ТУХАЙ.

- **Зохиомж** нь (**COMPOSITION**) бүтэц ,бүрэлдэхүүн ,нэгдэл ,зохиох, бүрдүүлэх ,байршуулах гэсэн утгатай латин үгнээс гаралтай.
- График дизайны зохиомжийг **хавтгайн зохиомж** гэдэг. Хавтгайн зохиомж гэдэг нь хоёр хэмжээст дэвсгэрт дээр гүйцэтгэгсэн зохиомжийг хэлнэ.
- Хавтгайн зохиомжийн үйл ажиллагаанд оролцож байгаа элементүүдийг гүйцэтгэх үүргээс нь хамааран **хэлбэрийн** ба **ЗОХИОМЖИЙН** гэж ангилна.
- График дизайны зохиомжийг өгөгдсөн сэдвийн хүрээнд **ЗОХИОМЖИЙН** ба **хэлбэрийн элементүүд**, мөн **байгуулалтын аргуудыг** ашиглан бүтээнэ.

ХАВТГАЙН ЗОХИОМЖИЙН БА ХЭЛБЭРИЙН ЭЛЕМЕНТУҮДИЙН АНГИЛАЛ.

Хавтгайн зохиомжийн элементүүд

Хэлбэрийн элемент

Зохиомжийн элемент

Цэг

Зураас

Дүрс

Байршил

Чиглэл

Хэмжээ

Өнгө

Хэлбэр

Материаллаг
шинж

ЗОХИОМЖИЙН ТӨВИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ .

- График дизайнд чухал үүрэг гүйцэтгэдэг ойлголт бол **ЗОХИОМЖИЙН ТӨВ** юм. Зохиомжийн төв нь тухайн бүтээлийн утга санаа, агуулгаа оновчтой илэрхийлхэд тустай. Зохиомжийн төв нь хүмүүст мэдээллийн агуулга, утга санааг богино хугацаанд хүргэх үүрэгтэй . Зохиомжийн төвийг оновчтой уран сайхнаар боловсруулахын тулд зохиомжийн хууль зарчим ,арга , элементүүдийг ашиглана.

ЗОХИОМЖИЙН ХУУЛЬ

Зохиомжийн хууль гэдэг нь тухайн уран бүтээлийн утга санаа, агуулгыг уран сайхнаар боловсруулан илэрхийлэхдээ дагаж мөрдөх үйл ажиллагааг хэлнэ.

Зохиомжийн хууль



Зохиомжийн **нэгдмэл байдал** гэдэг нь тухайн зохиомжид өгөгдсөн элементүүдийг холбон нэгтгэх шийдэл юм. Өгөгдсөн зохиомжид тархан тархан байрласан элементүүдийн цаана том дөрвөлжин дүрсийг дүрсэлсэнээр жижиг дөрвөлжнүүдийг дүрсэлсэнээр жижиг дөрвөлжнүүдийг холбон нэгдмэл байдлыг үүсгэжээ.




Зохиомжийн **бүхэл байдал** гэдэг нь зохимжийн элементүүдийн эмх цэгцгүй байдлыг эрэмблэн, зохион байгуулалттай цогц дүрслэл, шийдэлд оруулсныг хэлнэ.


БАЙГУУЛАЛТЫН АРГА

Зохиомжийн төв байгуулах аргууд.


Геометр
байгуулалтын
арга




Гэрэл
сүүдрийн
арга




Өнгийн эрс
ялгарлын
арга



Хэмжээсийн
арга



Хэлбэрийн
арга



ЗОХИОМЖИЙН ТӨВ БАЙГУУЛАХ АРГУУД.

Шоо дөрвөлжингийн диагоналийн огтлолцлыг зохиомжийн төв болгох аргыг **геометр байгуулалтын арга** гэнэ. Зохиомжийн төвийг яг голд байрлуулахаас гадна аль нэг тал руу нь шилжүүлэн байрлуулж болно.

Өгөгдсөн зохиомжийн төв нь гэрэл сүүдрээр ялгарах аргыг **гэрэл сүүдрийн арга** гэнэ. Өгөгдсөн зохиомжид цайвар саарал өнгийн гурвалжин нь бусад бараан саарал өнгийн гурвалжингуудаас ялгарч, зохиомжийн төв болж байна.

Өнгийн эрс ялгарлын арга гэж зохиомжийн төв нь өнгөөр эрс ялгарах аргыг хэлнэ. Өгөгдсөн зохиомжид улаан өнгийн гурвалжин нь бусад саарал өнгийн гурвалжингаас эрс ялгарснаар зохиомжийн төв болж байна.

Өгөгдсөн зохиомжийн төв нь бусад ижил элементүүдээсээ хэмжээгээр өөр байхыг **хэмжээсийн арга** гэнэ. Зохиомжид өгөгдсөн гурвалжингуудаас нэг гурвалжин нь хэмжээгээрээ эрс ялгарч, зохиомжийн төвийн үүргийг гүйцэтгэж байна.

Өгөгдсөн зохиомжийн ижил хэлбэр дүрс, хэмжээ бүхий элементүүдээс эрс өөр хэлбэрээрээ эрс ялгарахыг **хэлбэрийн арга** гэнэ.

ХЭЛБЭЭРИЙН ЭЛЕМЕНТҮҮД.

Цэг


Цэг нь чиглэлт чанаргүй ба өөрийн тодорхойлогдох хязгаарыг давбал цэгийн шинжээ алдаж дүрс үүсгэнэ. Цэгийн хязгаарыг түүний байрших орон зай, хавтгай дэвсгэртийн адилтгасан харьцаагаар тодорхойлно.



Цэг

Хэлбэрийн
элементүүд

Зураас



Зураас

Зураас нь хавтгайн зохиомжийн үндсэн элемент ба хэрчим, шулуун зураас, муруй зураас гэх зэрэг олон төрөлтэй. Зураас нь хэлбэр дүрс, дүр илэрхийлнэ.





Дүрс

Дүрсийг геометр ба байгалийн дүрс гэж ангилна. Геометр үндсэн дүрсэд гурвалжин, дөрвөлжин, тойрог орно. Байгалийн хэлбэр дүрс нь амьтан ба ургамлын хэлбэр дүрс болно.



Дүрс

ЗОХИОМЖИЙН ЭЛМЕНТУУД



Орон зай

Зай талбай болон урт өргөн гэсэн хэмжээсээр илэрхийлэгдэнэ

Өнгө

Дизайны зохиомжид өнгийн үндсэн шинж чанар ба хүрдийг ашиглана.

Хэмжээ

Эрс ялгаа ба давамгайлалын шинжийг үүсгэдэг.

Эрс тэс ялгаа

Хэлбэр хэмжээ, өнгөөр илэрхийлэгдэнэ

Тэгш ба тэгш бус хэм

Төвийн эргэлтийн тэнлэгийн гэж ангилна. Тэгш хэм нь тогтвортой байдлыг тэгш бус хэм нь тогтворгүй байдлыг үүсгэнэ

Хэмнэл давтамж

Зохиомжийг өвөрмөц болгодог. Бүрдүүлж байгаа элементээс нь хамааран өнгийн ба төвөгтэй хэмээн ангилна

ЗОХИОМЖИЙН ТӨРӨЛ

Нээлттэй ба хаалттай зохиомж нь тухайн зохиомжид өгөгдсөн элементүүдийн байршил, чиглэлээс хамаарна.



ДААЛГАВАР -1



Даалгавар 1. Зурагт өгөгдсөн зохиомжийн байгуулалт болон хэмнэл давтамжийг ажиглаад, дутууг гүйцээн зурна уу. (1.86 а дугаар зураг)



1.86 дугаар зураг. а.энгийн хэмнэл б.төвөгтэй хэмнэл

ДААЛГАВАР -2


Даалгавар 2. Зурагт өгөгдсөн зохиомжийн байгуулалт болон хэмнэл давтамжийг ажиглаад, дутууг гүйцээн зурна уу. (1.866 дугаар зураг)

б)



ДААЛГАВАР -3

Даалгавар 3. Өгөгдсөн 1.87 дугаар зургийн адил байгуулалтын нэгж дүрс зохиож, хээ угалз загварчлан зурна уу.




1.87 дугаар зураг.

Байгуулалтын нэгж дүрс ашиглан зохиосон хээ угалзын хувилбарууд


ДААЛГАВАР-4

Даалгавар 4. Өгөгдсөн 1.88 дугаар зургуудын зохиомжийн төвийг олж, дээр дурдсан аргуудыг ашиглан тайлбарлана уу. (1.24 дүгээр хүснэгт. Зохиомжийн төв байгуулах аргууд)

а




б



1.88 дугаар зураг. а.цэгийн зохиомж б.тойрог ба дүрсийн зохиомж



ГЭРИЙН ДААЛГАВАР



Асуулт даалгавар:

1. Дүрс, үсэг, орон зай ашиглан утга санааг илэрхийлэх, асуудлыг шийдвэрлэдэг уран сайхны үйл ажиллагаа дизайны ямар төрөл вэ?
2. График дизайны зохиомжийн элементийг нэрлэнэ үү.
3. Хэмнэл давтамжийг юунд ашигладаг вэ?
4. График дизайны хэлбэрийн ба зохиомжийн элементүүдийг бичнэ үү.